

**ҮРСЛЭГ
БОЙЖУУЛАХ,
ШИЛЖҮҮЛЭН
СУУЛГАХ**

Үрслэг бойжуулах ажлын дараалал

- Хүйтэн үед хучих
- Услах
- Элслэх
- Үрслэгийг агааржуулах
- Цөөлөх, чихлүүр шилжүүлэх
- Нэмэгдэл бордоогоор бордох
- Өвчин хортонтой тэмцэх
- Тэсвэржүүлэх
- Үрслэг гаргах, тээвэрлэх



1. Хүйтэн сэрүүн үед хучих

- Үрслэг ургах тохиромжтой температур өдөр +12+16 хэм, шөнө +8+10 хэм
- Үрслэг ургуулах үед гадны дулаан +3 хэмээс доош болсон үед хучиж бусад үед онгойлгож байна.

*Үрслэгийг өөртөө байгаа материал
ашиглан хучиж дулаална*



2. Усалгаа

Услах арга:

Үрслэг ургаж байгаа хөрс нь 1 см хатсан үед норгох байдлаар услана.

Усалгааг ихдүүлбэл:

Үрслэг сунана, хар хөл, мөөгөнцөр зэрэг өвчинөөр өвчлөнө.



3. Элслэх



1. Үрслэг цухуйснаас эхлээд анхны навч гарах хүртэлх хугацаанд маш амархан сунадаг.

2. Сунасан үед нь анхны навч хүртэл нь элсээр хучиж (булж) өгнө.

3. Элсээр булагдсан ишний хэсгээс нэмэлт үндэс гарч үрслэгийн ургалт эрчимжинэ.

Сунасан үрслэгийн өндөрссөн ишийг чийгтэй элс ба
хөрсөөр хучиж өгнө





4. Үрслэгийг агааржуулах

- Үрслэг ургах тохиромжтой хэмийг хянаж байхын тулд орчинд нь термометр байрлуулна.
 - Үрслэг соёолж эхэлснээс хойш ургаж буй орчинд тохиромжтой температураас дээш халсан үед дарлагын тагийг бага багаар нээсээр хойшид бүрэн нээдэг болно.
 - Ингэснээр үрслэгийн механик эдийн хөгжил сайжирч бахим бүдүүн иштэй сайн чанарын үрслэг ургана.
 - Их нартай үед тагийг онгойлгохгүй бол үрслэг наранд цонож түлэгдэж үхдэг.
- 

Агааржуулахын тулд тагийг мод, төмөр ашиглан тулж онгойлгоно





Цөөлөх, чихлүүр шилжүүлэх:

Энэ нь ургаж буй үрслэгийн хоорондын зайг тохиромжтой болгох арга юм

1. Цөөлөх:

Шигүү ургасан ургамлын зарим хэсгийг сугалж авахыг хэлнэ.

2. Чихлүүр шилжүүлэх:

Жинхэнэ навч нь дөнгөж цухуйж буй ургамлын үндсийг гэмтээхгүйгээр авч тохиромжтой зайнд шинээр суулгахыг хэлнэ

Үрийн тал гарах үеэс анхны навч гарах хооронд
5х5 см зайтайгаар шилжүүлэн суулгана.





Чихлүүр гэж юу вэ?



- Үр цухуйхын өмнөх үе
- Цухуйх
- Соёлох
- Чихлүүр
- Жинхэнэ навч гарах

Чихлүүр шилжүүлэх





Бордоо

- **Бууцны шингэн:** 40 кг бууцыг 200 л усанд бүрэн уусгаад 5 дахин шингэлж 100 м² талбайг услана.
- **Сангасны уусмал:** 10 кг сангасыг 200 л усанд бүрэн уусгаад 5 дахин шингэлж 100 м² талбайг услана.
- **Азотын бордоо:** 1 м² талбайд 30-40 гр бордоог жигд цацаад зөөлөн усалж шингээнэ.

Өвчин хортон

Байцааны хар хөл өвчин гарсан үед усалгааг багасгана. Дулааныг бууруулна.

Байцааны бүгэг, хивэнгийн авгалдайг гарсан үед 0.3 %-ийн децис ба сумацидины уусмалаар шүршинэ. (1 литр усанд 3 гр хор найруулна).

Чинжүү, өргөст хэмх гэх мэт таримлын үрслэг бөөстдөг. Энэ үед хлорофост ба метафостын 3 %-ийн уусмалаар шүршинэ.

Тэсвэржүүлэх



Ил талбайд гаргахаас 14 хоногийн өмнөөс:


1. Дарлагын үрслэгийг хучлагатай хонуулна.
2. Байранд ургуулсан бол цонх хаалгыг нээнэ.

7 хоногийн өмнөөс:

1. Дарлагын үрслэгийг таггүй хонуулна.
2. Байранд ургуулсан бол өглөө гаргаж орой оруулна.
Дулаан шөнө гадна хонуулна.



Талбайд шилжүүлэхэд бэлэн болсон үрслэг



Үрслэг тэсвэржүүлэх явцад даарч
хайрагдвал нар гарахаас өмнө
хүйтэн усаар шүршинэ.



Хайрагдсан үрслэгийг хүйтэн усаар шүршсэн байдал



Шүршсэний дараа



Үрслэг гаргах






- Үндсийг гэмтээхгүйн тулд 1 хоногийн өмнө маш сайн ханатал услана.
- Байрнаас гаргасан үрслэгийг 1-ээс илүү хонуулахгүй талбайд суулгана.
- Дарлагаас гаргасан үрслэгийг суулгах хүртлээ наранд гаргахгүй сүүдэр газар байлгана.

Үрслэг гаргахад бэлэн боллоо.




Арга ажиллагааны зураглал



Шилжүүлэхэд бэлэн болсон байцааны үрслэг




- 45-60 хоногийн настай
- 4-6 үндсэн навчтай
- Бахим бүдүүн иштэй
- Зөв хэлбэртэй (цөгц хэлбэртэй)
- Жинхэнэ навч нь нэг үе дээр байрласан.



Хэмхийн үрслэг

- 25-30 хоногийн настай
- 2-3 жинхэнэ навчтай
- Бүдүүвтэр хар ногоон иштэй
- Сунаагүй



Лоолийн үрслэг

- 60-70 хоногийн настай
- Цэцгийн бундуй үүсэхэд бэлэн болсон
- Сунаагүй үсэрхэг хүрэндүү ногоон иштэй
- 5-6 үндсэн навчтай



Үрслэг суулгах үеийн цаг агаарын нөхцөл

- Хурц наргүй
- Үүлэрхэг
- Шиврээ бороотой

Нөхцөлд суулгавал амьдрах
чадвар сайн байна.






Үрслэг шилжүүлэн суулгахад анхаарах зүйл

- Ургуулсан байрнаас нь гаргахаас 1 хоногийн өмнө ханатал усална.
- Үрслэгийг ургуулсан байрнаас нь авахдаа мөн суулгахдаа үндсийг нь гэмтээж болохгүй.

Шилжүүлэн суулгах үйл ажиллагааны дараалал





Үрслэг суулгах үйл ажиллагааны дараалал


- Талбайгаа засах
- Усалгааны шуудуу гаргах
эсвэл услах саваа бэлтгэх
- Тогоо гаргах
- Үрслэгээ суулгах
- Услах

Үрслэгийг анхны навч хүртэл буюу үндэсний хүзүүгээр нь суулгана



1. Хэт гүн, буруу суулгасан үрслэг
2. Зөв суулгасан үрслэг
3. Хэт өндөр, буруу суулгасан үрслэг




Үрслэг суулгах арга



- Цүүц хэлбэрийн зүйлийг ашиглан суулгаж болно.
- Зөөлөн хөрсөнд шууд хуруугаараа суулгаж болно.



Усалгаа



- Талбайг хайрцаглан зассан нөхцөлд бүх ургамлыг суулгаж дуусаад өдөрт нь багтаан хайрцагны хамрыг нь дүүртэл услана. Хайрцагийн хэмжээ 3х4 м, хамрын өндөр 15 см орчим байна.
- Тогоолж тарьсан нөхцөлд ургамал бүрийг 1.5-2 л усаар услана.
- Хамарлаж тарьсан нөхцөлд хамрын хоорондох сувгийг дүүртэл нь услана.

Үрслэг суулгасны дараах арчилгаа

- Хөрсний бүтцээс хамааран 1-5 хоноод дээрх байдлаар услана.
- Талбайн хөрс 3-5 см хатах бүрийд услана.
- Усалгаа бүрийн дараа 1 хоноод хөрсний өнгөн хэсгийг сийрүүлнэ.



Анхаарал хандуулсанд баярлалаа
Дараагийн хичээл хүртэл түр баяртай